

Батлав: БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН,
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА...../Б.БУЯННЭМЭХ/



Зөвшөөрч, хэрэгжүүлхүүрэг хүлээсэн:
“ЦЕМЕНТ ШОХОЙ” ХХК ИМИН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/Л.Наанбаатар/

“ЦЕМЕНТ ШОХОЙ” ХХК



СЭЛЭНГЭ АЙМАГ САЙХАН СУМ ХӨТӨЛИЙН
“ЦЕМЕНТ ШОХОЙ” ХХК-ИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР
MY-12219A, MY-15249A
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР-2641984/

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН...../П.ШИНЭЦЭЦЭГ/

БОЛОВСРУУЛСАН:

“Цемент Шохой” ХХК-ийн
БОХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ.....*З. Болортuyaа*...../З.Болортuyaа/
БОНСЭРГЭЭЛТИЙН МЭРГЭЖИЛТЭН.....*-Т. Уртнасан*...../Т.Уртнасан/

Агуулга


1.	Төслийн танилцуулга	3
1.1	Хөтөлийн Цемент Шохойн үйлдвэр	3
1.2	Шохойн чулууны орд	6
2.	Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	8
3.	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	8
4.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13
5.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	21
6.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
7.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	23
8.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	23
9.	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	24
10.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	26
12.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	34
13.	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	39
	Зардал нэгтгэл	40

1. Төслийн танилцуулга

Хөтөлийн “Цемент Шохой” ТӨХК-ийн Байгаль орчныг хамгаалах бодлогын гол зорилго нь “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай” болон бусад холбогдох хууль, дүрэм, журам, компанийн үндсэн бодлогын дагуу явуулахад оршино.

1.1 Хөтөлийн Цемент Шохойн үйлдвэр

Хөтөлийн “Цемент Шохой” үйлдвэр нь 1983 оны 10-р сараас эхлэн 40 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Тус үйлдвэрийн газар нь Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт, Дархан-Уул аймгаас урагш 60 км, Орхон аймгаас 120 км, Улаанбаатар хотоос 260 км-т зайд тус байрладаг.



Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт Хөтөлийн шохойн чулууны ордыг түшиглүүлэн Цемент Шохойн үйлдвэр барих тухай Улсын Төлөвлөгөөний комиссын шийдвэр 1978 онд гарч тухайн үеийн ЗХУ-ын Новосибирск хотын “СИБНИЙ ПРОЕКТ ЦЕМЕНТ” эрдэм шинжилгээний хүрээлэнд зураг төсвийг зохиож барилгын ажлыг 1981 оноос эхлүүлсэн түүхтэй.

Шохойн үйлдвэр нь жилд 65.0 мян.тн шохой үйлдвэрлэх хүчин чадалтайгаар 1984 оноос, Цементийн үйлдвэр жилд 500.0 мян.тн цемент үйлдвэрлэх хүчин чадалтайгаар 1985 оноос эхлэн одоог хүртэл үйлдвэрлэлээ тасралтгүй явуулж байгаа ба 2014 оноос хоногт 2500 тн чулуунцар үйлдвэрлэх хүчин чадалтай цементийн хуурай аргын үйлдвэр ашиглалтанд орсон бөгөөд хуурай технологийн үйлдвэрийн хүчин чадал нь 500.0 мян.тн юм.

Тус үйлдвэрт нийтдээ 820 орчим ажилчид ажилладаг бөгөөд дулаан үйлдвэрлэх, хангах түгээх охин компани “Хөтөл энержи” ХХК, Чулуунцарын үйлдвэр, Цементийн үйлдвэр, Шохойн үйлдвэр, Геологи уул уурхай, Механик засвар, Эрчим

зүй, Сорилт шинжилгээний лаборатори, Борлуулалт логистикийн алба, Захиргаа гэсэн үндсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Эрчим хүчиний хангамж: Цахилгаан эрчим хүчийг Дархан хотоос 110 квт-ын шугамаар Хөтөлийн ГПП 110/35/6 квт-ын дэд станцид хүлээн авч Шохойн үйлдвэрийн “ТП” 2-р станциар дамжуулан хуваарилана.

Цэвэр усны хангамж: Ус хангамжийн эх үүсвэр нь үйлдвэрлэлийн талбайгаас 20 км-т, Орхон сумаас 2,5 км зайд Орхон голын хөндийд оршино. Ус хангамжид 50-57м үн бүхий 50-83л/сек ундаргатай 3 өрмийн цооногоос авч байна. Усны чанар, түүнийг цэвэршүүлэлтийг мөрдөгдөж буй стандартын дагуу гүйцэтгэж байна.

Ус хангамжийн сүлжээнд:

- Ус хураагуурын цооногууд
- Магистрал шугам (2 дахь өргөлтөөс үйлдвэрийн талбай хүртэл)
- 3 ба 4 өргөлтийн насосын станцууд
- Усан сан

Тус үйлдвэрт ахуйн ус хангамжид зориулсан нэгдсэн систем байгуулагдаж, бохир ус цэвэршүүлэх байгууламжид үйлдвэрийн хаягдал ус болон ахуйн ус түгээгүүр хамарагддаг болно.


Үйлдвэрийн талбайн гаднах сүлжээ ба цэвэршүүлэлтийн байгууламжид:

- Даралтат өөрөө урсах коллектор (Үйлдвэрийн талбайгаас цэвэршүүлэх байгууламж хүртэл)
- Цэвэршүүлэлтийн насосын станц
- Цэвэршүүлэх сүлжээний байгууламжийн цогцолбор
- Цэвэршүүлсэн усны даралтат өөрөө урсах коллектор орно.

Төслөөр хэрэгжүүлсэн цэвэршүүлэх байгууламж бүхэлд нь цэвэршүүлэхээр тооцсоноор хоногт 2133 м³ ба цэвэршүүлэлтийн ууршуулалтын талбайгаас 1 км зайд задгай зайлзуулна.

Үйлдвэрийн бохир усны систем: Үйлдвэрлэлийн технологиос гарах пульпыг тусгай тунгаагуур, цэвэр усны сан хоёроор дамжуулан цэвэршүүлэн тунгалагжуулдаг тул үйлдвэрлэлийн технологийн хаягдал бохир ус гардаггүй. Харин ажиллагсдын унд ахуйн болон ариун цэврийн өрөө, халуун усны хэрэглээнээс гарсан бохир усиг хотын ариутгах татуургын нэгдсэн сүлжээнд нийлүүлэн хаядаг. Үйлдвэрийн газарт хамаарах бохир усны сүлжээний нийт урт 0,6 км. Энэ сүлжээгээр хоногт 3,8 м³ буюу жилд дунджаар 1,368 мян.м³ бохир зайлзуулагдах бөгөөд хаягдаж байгаа ус нь зөвхөн ахуйн бохирдолтой юм.

Үйлдвэрийн дулааны хангамж: Үйлдвэрийн харьяа дулааны станц нь өөрийн үйлдвэрээс гадна Сайхан сумын Хөтөл хотыг дулаанаар ханган ажиллаж байна.



Шуудан холбоо: Хөтөлийн "Цемент-Шохой" ТӨХК нь Улаанбаатар хот болон бусад аймаг, гадаад орнуудтай шууд харилцах телефон холбоотой, мэдээллийг факсаар солилцох бүрэн боломжтой.

Чулуунцар үйлдвэрлэл нь автоматжуулсан үйлдвэр ба хоногт 2500 тонн чулуунцар үйлдвэрлэх хүчин чадалтай.

Тоог төхөөрөмжийн нэр	Хүчин чадал
Хос роторт бутлуур	900 тонн/цаг
Шохойн чулууны жигдрүүлэх агуулах	73,000 тонн
Булт тээрэм	210 тонн/цаг
Эргэх зуух Ø-4м, 60м	2,500-3,000 тонн/цаг
Нүүрсний тээрэм	18-20 тонн/цаг
Цементийн тээрэм 3 ширхэг	3×50 тонн/цаг
Нүүрсний жигдрүүлэн нуруулдах агуулах	15,000 тонн
Цементийн силос	16,000 тонн
Цементийн савлах машин 3 ширхэг	300 тонн/цаг

Шохойн үйлдвэрлэл нь жилд 65 мянтн шохой үйлдвэрлэх хүчин чадалтай. Тус цех нь хоногт 70 тн бүтээмжтэй ажиллах шохойн чулууг шатаах 3 зуухтай. 0-3 мм ширхэглэлээр нарийн бутлагдсан 70%-иас доошгүй идэвхжилтэй шохойг жилд 65 мянтн гаргахаар төлөвлөсөн бөгөөд эхний жилүүдэд нунтаг шохой, сүүлийн жилүүдэд 80%-иас доошгүй идэвхжилтэй бүхэл шохойг үйлдвэрлэн Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-т нийлүүлж байна.

1.2 Шохойн чулууны орд

1961 онд Дарханы районд хийгдсэн 1:200000 масштабтай эрэл зураглалын ажлаар Орхон голоос зүүн урагш 25км-т протерозойкембрийн элсэн чулуу, занарын дунд шохойн чулууны линз хэлбэрийн биетийг илрүүлсэн. 1962 онд тус районд хийгдсэн 1:25000 масштабтай эрлийн ажлын үр дунд шохойн чулууны хэд хэдэн линз илрүүлсэн. Линз ирүүлснээс Хөтөлийн шохойн чулууны орд юм. Шохойн чулуу нь суналын дагуу 2750м баруун урагшаа 45-50 градус суналттай, биетийн зузаан нь 100м гэж тогтоожээ. Мөн 2014 онд Андреев А.А шохойн чулууны илэрц дээр геологийн урьдчилсан хайгуулын ажил хийж ордын төв хэсгийг В-С1 зэргээр зүүн ба баруун жигүүрийг С1-С2 зэргээр нөөцийг тогтоосон.

Орд нь геологийн тогтоцын хувьд хувиралд орсон элсэн чулуу, занар, шохойн чулуунаас тогтох бөгөөд профиритын дайкаар хэрчигдэж дөрөвдөгчийн сэвсгэр хуудсаар хучигдсан байна.


Хөтөлийн шохойн чулууны орд нь структурын харьцааны хувьд антикналь атираажлийн өмнөд жигүүрийн хэсэгт профиритын дайка болон тектоникийн эвдрэлтэй орон зайн хувьд холбоотойгоор үүссэн. Ордын геологийн литологийн зүсэлтийг үзүүлбэл:

1. Элсэн чулуу бараан саарал өнгөтэй, янз бүрийн ширхэглэлтэй уналтын азумит 170-190⁰
2. Шохойн чулуу саарал өнгөтэй, гантигжсан, доломитлогжих процесс орсон, CaO 34%, MgO 14%, хурдасны зузаан 30м. Занар хлоржих процесст орсон ногоовтор туяатай, бараан саарал өнгөтэй, үзэгдэх зузаан нь 20-30м.
3. Шохойн чулууны доод дээд хэсэг нь цайвар саарал өнгөтэй, гантигжсан зузаалгын дунд хэсэгт нь саарал өнгөтэй, жижиг ширхэгтэй шохойн чулуу, доломитжих процесст бага зэрэг орсон MgO-1.5-3.0%.
4. Хурдаслаг чанар хлоржих процесст орсон ногоовтор өнгөтэй, бараан саарал туяатай, үзэгдэх зузаан нь 100м шохойн чулууны үеийг хучиж байрласан. Ордын нийт талбай нь элсэн чулуу, занар, шохойн чулууны хэмхдэс материал агуулсан боровтор саарал өнгийг дөрөвдөгчийн хурдасаар хучигдсан байна. Энэ хурдасны зузаан нь 0.5-12м.

Шохойн чулууны орд нь засаг захиргааны хувиарлалтаар Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт “Шохойн нуруу” хэмээх газарт байрлах ба ашиглалт явуулах MY-12219A, MY-15249A тоот зөвшөөрлийн талбайд байрлана.

Тус орд нь газар зүйн байрлалаараа Монгол орны Хангайн уулын бүсэд хамаарагдах ба, далайн түвшнээс дээш 1000-1500 м өндөрт өргөгдсөн хэсэгт оршино.

Хөтөл-1 ордын шохойн батламжлагдсан үйлдвэрлэлийн нөөц 1980 оны 11-р сарын 3-ны байдлаар B+C1 зэрэглэлээр 47,6 сая.тн, үүнээс шохойн түүхий эд 14,8 сая.тн, ба цементийх 32,8 сая.тн болно. Төмөртолгойн ордын төмрийн худрийн нөөц B+C1 зэрэглэлээр 3,7 сая.тн байгаа нь тус үйлдвэрийг 50 жил хангахадхүрэлцээтэй юм. Тус заводын хэрэгцээнд зориулсан шохойн чулууны ил уурхайн хүчин чадал жилд 1015 мян.тн, үүнээс 790 мян.тн нь шохой, цемент болон товарын шохойн чулуу



үйлдвэрлэх сайн чанарын шохойн чулуу бөгөөд 225 мян.тн нь цемент үйлдвэрлэлийн зориулалттай карбонат багатай шохойн чулуу байна.

Урьдчилсан хайгуулыг явуулахдаа баганат өрөмдлөг, суваг, шурф малтальтын ажил хийж, нөөцийг +940-р түвшин хүртэл тогтоожээ. Тус ордыг түшиглэж жилдээ 500.0мян.тн 400 маркийн портланд цемент үйлдвэрлэх хүчин чадалтай цементийн үйлдвэр, 65мян.тн шохой үйлдвэрлэх хүчин чадалтай шохойн үйлдвэр барих болсондой холбогдуулан 1975-1976 онд барилгын материалын экспедицийн №7 анги нарийвчилсан хайгуул хийсэн.

Шохойн чулууны ордыг геологийн тогтоц хэмжээ чанараас хамааруулж 2-р группт хамааруулжээ. Хайгуулын шугмуудын хоорондын зайл В зэргээр нөөц бодсон талбайд 90-160м-р C1 зэргээр нөөц бодсон талбайд 180-340м-р авчээ.

1976 онд Хөтөлийн шохойн чулууны орд дээр 23 цооног буюу 2035 уртааш метр өрөмдлөгийн ажил хийжээ. 1980 онд Ш.Доржсүрэн, К.Ш.Фаткуллан, С.Н.Кальсан нар 1962-1963, 1975-1976 онуудын урьдчилсан болон нарийвчилсан хайгуулын ажлын тайлангийн материал хими шинжилгээний үр дүнг үндэслэн барилгын шохой үйлдвэрлэх чиглэлээр нэмэлт судалгаа хийж гүйцэх судалгааны тайлан бичсэн байна. Үүний үр дүнд ордын нөөцийг 1980 оны 01-р сарын 01-ний байдлаар УАМНК-оор батлуулжээ. Ордыг ашиглах явцад 1980 оны дээрх батлагдсан нөөцийн чанар, тоо хэмжээ, хил хязгаарт өөрчлөлт их хэмжээгээр гарч, нөөц тооцож үйлдвэрийг түүхий эдээр хангахад хүндрэл учирснаас тэр үеийн

Үйлдвэрийн захиргаа 1988 онд Улсын Барилгын Хороонд /УБХ/ Хөтөл-1 ордын төв хэсэгт гүйцэх хайгуул, нөөц Хөтөл-2 ордод нарийвчилсан хайгуул хийлгэх хүсэлт тавьснаар уг ордын ашиглалт эхэлсэн.

1992 онд Эрдэнэтийн УБҮ-ийн хайгуулын ангид ашиглалтын хайгуул хийлгэх захиалга өгч дээрх захиалгын дагуу ордын төв хэсэгт хайгуулын шугам 1-ээс 22-ын хооронд өөрөөр хэлбэл ордын баруун талын II шугмаас зүүн талын III шугмын хооронд +930-р түвшин хүртэл нарийвчилсан хайгуулын схемээр ашиглалтын хайгуул өөрийн хөрөнгөөр хийж ойрын жилүүдэд ашиглах ашигт малтмалын геологийн тогтоц, тоо хэмжээ, хил хязгаарыг тогтоож, нарийвчилсан хайгуулын нөөцийн баталгааг дүгнэж, тодруулах боломжтой болсон.

2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Энэхүү газар нутаг нь хөрс газарзүйн мужпалтын хувьд био уур амьсгалын Төв Азийн их мужийн Хангай Хэнтийн өмнөдийн дэд мужид хамаарна. Энд хуурай хээрийн тал, хотгор, жижиг цав толгодын нунтаг карбонатлаг хар хүрэн, уугуул хэлбэрийн чулуурхаг нимгэн ба гүйцэд хөгжилтэй хөрс зонхилно.

Харин шохойн чулууны орд нь тектоникийн хөдөлгөөнөөр уулын цул газрын гадаргад ил гарч бутран тархасны улмаас гүвээ толгод хэлбэртэй гадаргуу болон тогтжээ. Энэ гадаргуугийн чулуулгийн зайд, завсар элэгдэл, хуримтлалаар дүүрч өнгөн хөрс бүрдэх нөхцөл болсон байна. Иймээс ордын дээр бүрэлдэн тогтсон хөрсний зузаан янз бүр зарим хэсэгт 1.5м байхад зарим газартаа 5 м хүртэл зузаантай байдаг байна. Энэ хөрс нь механик бүрэлдэхүүнээрээ шавранцар бөгөөд хүчиллэг талст чулуулаг дээрх уулын хүрэн хөрсөнд тооцогдоно.

Жалга хөндийн хэсгээр элэгдэл хуримтлалын шинжтэй, усны зөөгдлөөр үүссэн хөрсөн бүрхэвч зонхилно. Уурхайн ухсан хэсгээс хөрсний тогтоцыг үзэхэд эндэхийн хөрсний шилжилт нь тод ялгаран харагдах бөгөөд ерөнхийдөө турван үе давхаргаас тогтсон байна. Үүний дээд хэсэг нь тоосорхог, хөнгөн цавранцар механик бүрэлдэхүүнтэй, азот, фосфорын хангамжаар муу, калийн хангамж дунд зэрэг, хөрсний уусмалын орчин саармаг, ялзмагийн хэмжээ багавтар давсжаагүй, ургамлын үндэсээр баяраг байхад дундах үе нь тоосорхог шавар механик бүрэлдэхүүнтэй, маш их давсжсан, сульфатын ион зонхилсон, хөрсний уусмалын орчин сул шүлтлэг цайвар бор өнгийн хөрс байна.

3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Энэхүү төлөвлөгөөний гол зорилт нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах байлаа.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж ажиллана.

Цемент, шохой үйлдвэрлэх технологийн үе шатуудад орчинд утаа, тоосжилт үүсгэх сөрөг нөлөөлөлтэй.

Иймд бид Сэлэнгэ аймгийн Цаг уур орчны шинжилтгээний газартай гэрээ байгуулан агаар, хөрсний шинжилгээг тогтмол хийлгэж ирсэн ба шинжилгээний дүнгээр илэрсэн сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.

“Цемент Шохой” ТӨХК нь 2023 онд Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн болно.

Үүнд:

- Агаарын чанар: 2023 оны 5,10 саруудад /2 удаа / Сэлэнгэ аймгийн Цаг Уур Орчны шинжилгээний төвөөс 2 хүний бүрэлдэхүүнтэй лаборатори шинэжээч үйлдвэрийн хашаан дотроос гэрээнд заагдсан 5 цэгээс агаарын шинжилгээний дээжийг авч тухай бүр хариуг ирүүлсэн болно. Шинжилгээгээр азотын давхар исэл, хүхэрлэг хий, нийт тоосны хэмжээг тодорхойлдог ба бүх үзүүлэлтүүд MNS4585:2016 стандартад заагдсан хүлцэх агууламжаас даваагүй. Харин нийт тоос, нарийн ширхэглэгт тоосонцор /PM2.5/, том шрхэглэгт тоосонцор давсан үзүүлэлттэй гарсан.
- 2023 онд дараах цэгүүдээс агаарын шинжилгээ авна.

№	Агаарын шинжилгээний дээж авах цэг
1	Цементийн үйлдвэрийн тээрэмдэх хэсэг
2	Цементийн үйлдвэрийн савлах хэсэг
3	Шохойн үйлдвэрийн гадна байрлах овоолго
4	Шохойн үйлдвэрийн бутлуурын овоолго
5	Чулуунцарын үйлдвэрийн нүүрс хүлээн авах талбай

- Ус: Үйлдвэрийн шугамын усыг 2023 оны 5 болон 10-р саруудад буюу нийт 2 удаа шинжилгээнд хамруулсан ба Сэлэнгэ аймгийн Ус Цаг Уур Орчны шинжилгээний төвийн Байгаль орчны лабораториид шинжилгээнд. Уг шинжилгээний дунд усны химийн чанарын ихэнх үзүүлэлтүүд нь ундны ус болон ахуйн зориулалтаар хэрэглэх, усны чанар аюулгүй байдлын хяналт шинжилгээний MNS 900:2018 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс даваагүй байсан.
- Байгаль орчин аялал жуулчлалын сайдын A/160 тушаалаар томилогдсон идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмал олборлох, баяжуулах, боловсруулах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж буй




бохирдлыг судлах, байгаль орчны багц хуулийн хэрэгжилтэд газар дээр нь ажиллах дүн шинжилгээ хийх үүрэг бүхий “Байгаль орчны судалгаа шинжилгээний төв”-ийн УТҮГ-ын захирал Х.Ганбаатар ахалсан ажлын хэсэг 2023 оны 08 дугаар сарын 14-ны өдөр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дэргэдэх Хяналтын төв лабораторид ундны ус болон гүний худагт MNS 900:2018, MNS ISO 11885:2011 /ICP/ стандартын дагуу дүн шинжилгээ хийлгэхэд агрохимийн үзүүлэлтүүд зөвшөөрөгдөх хэмжээнээс даваагүй хэвийн гэж дүгнэлт гарсан.

- **Хөрсний чанар:** Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрсний хяналт шинжилгээг 2023 оны 5 болон 10-р саруудад Сэлэнгэ аймгийн Цаг Уур Орчны шинжилгээний төвөөс Байгаль орчны лабораторитай байгуулсан гэрээний дагуу 2 удаа явуулсан. Үйлдвэрийн хашаан дотроос 3, 2 цэгт хөрсний дээжийн хяналтын цэгээс MNS 3297:2019 агрохимийн үзүүлэлт, MNS 6838:2020 нефтийн бүтээгдэхүүн, MNS 5850:2019 хүнд металл зэрэг стандартын дагуу хөрсний дээж авч шинжлүүлэхэд үзүүлэлтүүд стандартаас даваагүй хэвийн байв.

Мөн “Байгаль орчны судалгаа шинжилгээний төв”-ийн судалгааны ажлын хэсэг 2023 оны 08 дугаар сарын 14-ны өдөр үйлдвэрийн хашаан дотор болон Хөтөл 1, 2 ил уурхай, хогны отвал орчмын 15 цэгээс дээж авч итгэмжлэгдсэн “Хан лаб” ХХК-аар шинжлүүлэхэд MNS 5850:2019 хөрсний агрохимийн үзүүлэлт, хөрсний механик бүрэлдэхүүн, хүнд металл, MNS 3297:2019 хөрсний эрүүл ахуйн үнэлгээ зэрэг стандартаас даваагүй байв.


Бид хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж ажиллаж байна.

Хөтөлийн Цемент Шохойн үйлдвэр ба шохойн чулууны ордод сөрөг нөлөөллийн үйл ажиллагааг хамтад нь дараах байдлаар гүйцэтгэсэн болно.




Үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэж буй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд тухайн районд ногоон байгууламжийг сайжруулах, нөхөн сэргээлт болон орчны усалгаа, тохижилтын ажлыг жил бүр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажилладаг.

Цемент Шохой ХХК-ний биологийн нөхөн сэргээлт хийх талбайн зураг



Цемент Шохой ХХК-ний техникийн нөхөн сэргээлт хийх талбайн зураг



Хөтөлийн Цемент Шохойн үйлдвэр сэргэг нөлөөллийн үйл ажиллагааг дараах байдлаар гүйцэтгэсэн болно.

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэж буй сэргэг нөлөөллийг бууруулахын тулд тухайн районд ногоон байгууламжыг сайжруулах, нөхөн сэргээлт болон орчны усалгаа, тохижилтын ажлыг жил бүр Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

“Цемент Шохой” ТӨХК-ийн шохойн чулуу олборлох үйл ажиллагааг ТЭЗҮ-д тусгасны дагуу хэрэгжүүлж байгаа ба ТЭЗҮ-ний шинэчилсэн хувилбарыг 2016 онд Ашигт Малтмалын газар баталгаажуулсан болно.

“Цемент Шохой” ТӨХК нь 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд нийт 49,508,100 (дөчин есөн сая таван зуун найман мянга нэг зуу) төгрөг төсөвлөсөн байна.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа “Цемент Шохой” ХХК-ийн 2022 оны Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний үйлдвэрийн нэмэлт тодотголын тайлан, 2023 оны Хөтөл-1, Хөтөл-2 шохойн чулууны ордын БОННҮ-ний нэмэлт тодотголын тайлан болон 2023 онд гүйцэтгүүлсэн Байгаль орчны аудитын тайланг тус тус үндэслэл хийсэн.

4. Сэрг нөлөөллийг буурулах арга хэмжээний төлөвлөгөө

Агаарын чанар:

№	Гол болон болзошгүй сэрг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сэрг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сэрг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төр	Тоо хэмж ээ	Нийт зардал, төг	Хэрэгжүү лэх хугцаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Сэрг нөлөөллийг бодитор тодорхойлж, бууруулах	Уур амьсталд нөлөөлөх сэрг нөлөөлтийг бууруулах чиглэлээр PM2.5, нарийн тоосонцорыг эх үүсвэр дээр хяналт тавих /ОХШХ-еөс харах/	Чиглэлээр бууруулах чиглэлээр PM10, нарийн тоосонцорыг эх үүсвэр дээр хяналт тавих /ОХШХ-еөс харах/	Үйлдвэрийн бүх орчин	Мг/г	-	-	ОХШХ-т тусгав	Тогтол
2	Агаар орчин болон ажилчдын мэндэд үзүүлэх сэрг нөлөөлөл буурах	Агаар орчин болон эрүүл мэндэд төхөөрөмжийн дотоод шаталтат хөдөлгүүр	Үйлдвэрийн бүх ажлын байруудын эрүүл ахуйн нөхцөлд хяналт тавих /ОХШХ-еөс харах/ Тоног	Үйлдвэрийн бүх орчин	Мг/г	-	-	ОХШХ-т тусгав	Улирал бүр
3	Агаарын тоосжилтыг бууруулах	Агаарын тоосжилтыг бууруулах	Үйлдвэрийн бүх орчин	Мг/г	-	-	200,000	Улирал бүр	MNS4585:2016

4	боловн халаалтын том, жижиг зуух, цахилгтан үүсгүүрийн хаягдаал угаанд хорт хий, тоос багасгах шүүлтүүр тавих, утааны шүүлтүүрийг тогтмол солих	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор технологийн үйл ажиллагаа явагдах замуудад усалгааг тогтмол хийх	Үйлдвэри йн бүх орчин	Мгр -	Хувьшигийн н дагуу	MNS4585:2016
5	Шохойн үйлдвэрийн гаднах чулгулийн овооптыг чулгуулж 2024 онуудад шат дараалалтайгаар үлдэрлэлд ашиглаж орчныг цэвэрлэх	Шохойн чулгуу шатаах тарч буй хий, тоосонцор агаарт дэгдсэнээр учирч аюул, туунээс урьдчилан сэргийлэх, үүссэн	Үйлдвэри йн бүх орчин	Мгр -	Үйлдвэрлэ лийн зардалд орж тооцогдсон болно.	Tогтмол MNS4585:2016

	тохиолдолд замар хамгаалах, арилгах талаар ажилчдыг сургалтанд хамруулж, мэдлэгийг дээшлүүлэх						700,000	

ДҮН

Гадарын ба газрын доорх усны нөөц

№	Гол болон нэлзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжи х НЭРК	Нэгжийн зардал, төг	Тоо хэмж ээ	Нийт зардал, төг	Хэрэгжүү лэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Газрын усны доорх нөөцийн хомсдол, барагдаалт уссэх серөг нөлөөлөл	Ус дүгнэлт гаруулах	Ашиглах	Үйлдвэрийн өөрийн худаг	Mг/л	-	-	1.100.200	2-р сард
2		Усны эх үүсвэрийн худгийг тоолууржуулах	ЭХ	Үйлдвэрийн өөрийн худаг	Mг/л	-	-	200.000	Тогтол
3	Ундны усанд гарах нөлөөлөл	Үйлдвэрт ашиглагдаж байгаа бохир хяналт мониторинг явуулах /ОХШХ- өөс харах/	Цэвэр, усанд	Үйлдвэрийн өөрийн худаг	Mг/л	-	-	ОХШХ-т тусгав	Улирал бүр

4	Үс хангамжийн худгуудын орчны бохирдлыг цэвэрлэж, эрүүл бус тогтоож, хаалт хамгаалалтыг сайжруулан хаягжуулж, анхааруулах санамж, тэмдэг, тэмдэглэгээ хийж, УУСВЭРИЙН эрүүл ахуй, хамгаалалтын бусийн дэлгэмийг баримталж ажиллах	Үйлдвэрийн өөрийн худаг	Мг/л	-	400,000	Тогтмол
5	Үйлдвэрийн хэмжээнд үнданд хэрэглэж буй усны серег нэлөө	Үйлдвэрийн үеийн худаг	Мг/л	-	-	Тогтмол
6	Гүний усны Уссэж буй нэлөөлөл	Гүний усны Нөөц, чанарт байнгын хяналт тавьж,	Үйлдвэрийн өөрийн худаг	Мг/л	-	Улирал бур

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө - 2024 он

	Түвшний хэмжилт, дээжтэлт хийж, баримтжуулах								1,700,200		
	ДҮН										

Хөрсөн бүрхэвч

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллиүд	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжи х нэгж	Нэгжийн зардал төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хөрсний алдагдах нөлөөлөл	Хөрсний чанарын дотоод хяналтыг хийх /ОХШХ-өөс харах/ чанар сөрөг	Хөрсний чанарын дотоод хяналтыг хийх /ОХШХ-өөс харах/	Үйлдвэрийн бүх орчин	Mr/kg	-	-	ОХШХ-т тусгав	Тотгмол	MNS5850:2008
2		Хөрсөнд агуулах хүнд хортой элементийн агууламжийг тодорхойлох	Хөрсөнд агуулах хүнд хортой элементийн агууламжийг тодорхойлох	Засварын хэсэг, СШЛ, Чулуунчарын үйлдвэр	Mr/kg	-	-	200,000	Тотгмол	MNS5850:2008
3	Хөрс сөрөг нөлөөлөл	Хөрсний хүнд металл хэмжээнээс их илэрсэн хэсэгт хөрсний	Хөрсний хүнд хүлцэх хэмжээнээс их илэрсэн хэсэгт хөрсний	Үйлдвэрийн бүх орчин	Mr/kg	-	-	300,000	Тотгмол	MNS5850:2008

		Сийрэгжүүлэлт хийх							
№	Хөрс элэгдэж, урьдчилан сэргийлэх	Цэвэрлэгээний тоосноос үзсэн бодирдсон ногоон байгууламжын хөрсүг цэвэрлүүлж бордох		Үйлдвэрийн бүх орчин		Mr/kg	-	321,200	Хувиарын дагуу
		ДҮН							

Ургамлан нэмрэг

№	Гол ба болзошгүй серег нөлөөлөл	Серег нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Серег нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа ны улмаас зүйл устах серег нөлөөлөл	Ургамлан нэмрэгийн судалгааны ашиглан биомасс, ургамлын бүрэлдэхүүнийг тодорхойлох	Үйлдвэрийн хаашааны гадна	Ш	40,000	2	80,000	Жилид 2 удаа	-

2	Ургамлыг хамгаалах чиглэлээр ажилчдын мэдлэгийг дэшшүүлэх сургалт зохион байгуулах	Үйлдвэрийн нийт ажилтнууд	Ш	-	2	-	Жилд 2 удаа	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.16
						80,000		

Амьтны аймаг

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Малтсан нүх, хонхор, мөргөцөг рүү ойролцоох айтуудын мал унах, дарагдах, дайруулахаас сэргийтж, уурхайн эдэлбэр				-	-	2	Жилд 2 удаа ойролцоох иргэдэд анхааруулга өгөх	

	газарт тэмдэглэгэ э хийх, иргэдэд анхаарула х							
2	Зэрлэг амьтдыг тоолох, бүртгэх, популяци, нуудэл, зүйлийн бүрдлийг судлах хээрийн бичиглэлий насуултыг нуудлийн хугацаанд 5, 9-р сард жилд 2 удаа/	Шохойн чупууны орд	ш 40,000	2	80,000	Жилд 2 удаа -		

5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Техникийн нөхөн сэргээлт	Орхон суманд эвдрэл доройтолд орсон талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	га	0.7 га	3,000,000	2,100,000	2024 оны 5-7 дугаар саруудад хийж гүйцэтгэнэ	MNS 5917:2008
2.	Биологийн нөхөн сэргээлт	Орхон суманд эвдрэлд орсон талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийнэ.	га	1.7	2,500,000	4,250,000	2024 оны 5 дугаар сард хийж гүйцэтгэнэ	MNS 5918:2008
3.	Татан буулгах, хаалтад бэлтгэх	Ийм талбай одоогоор байхгүй байна.	-	-	-	-	-	-
		Нийт				6,350,000		

6. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Монгол улсын Засгийн газрын 5.1.8 дахь заалт “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдээрч олон жил орхигдсон 8 мянган га талбайг нехөн сэргээнэ” гэсэн зорилтын хүрээнд Сэлэнгэ аймгийн БОДЖГ-аас заасан солбицолын дагуу Ерөө сумын 3-р баг, Бугант тосгонд нөхөн сэргээлт хийх.	-	-	10 га	2,500,000	25,000,000	2024 оны 3-р улиралд	MNS 5917.2008

7. Нуулгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нэлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох асуудал байхгүй.	-	-	-	-	-	-	-
	Нийт					-		

8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нэлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Археологийн дурсгал	Байхгүй.	-	-	-	-	-	-
2.	Палеонтологийн дурсгал	Байхгүй.	-	-	-	-	-	-
	Нийт				-			

9. Осоп, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

/Химиин бодисын эрсдлийг бууруулах, урьдчилан сэргшлэх менежмент төлөвлөгөө/

№	Гүйцэтгэх ажил	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Харцуулах эзэн
1	Химийн хорт болон аюултай бодисыг стандартын шаардлага хангасан агуулахад зохиц дүрэм, журмын дагуу хадгалж, ашиглаж, устахаа үйл ажиллагааг аюулгүй зохион байгуулах	2024	СШЛабораторийн эрхлэгч, ХАБЭА, БОХэлтэс
2	Химийн хорт болон аюултай бодис хадгалах складыг зохих журмын дагуу ашиглаж, тогтмол хараа хяналттай, цоожтой байглаж, хаалтыг лацаах	Тогтмол	Инженер /Аналатик/, Техникийн менежер, нярав
3	Хадглж байгаа химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа боодол дээр тухайн бодисын нэр, анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарыг харуулсан тод, том шошго зэргийг шинэчлэн хадглаж байрлуулах	2-р улиралд	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналатик/, Техникийн менежер
4	Химийн хорт болон аюултай бодис ашиглахтай холбоотой үйл ажиллагааг хөдөлгөрийн аюулгүй байдлын нөхцөл, шаардлагыг бурэн хангасан зориулаалтын байр, талбайд явуулах	Тогтмол	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналатик/, Техникийн менежер
5	Ажлын байран дээр ашиглалдаж байгаа химийн бодисуудыг хадгалж буй шүүгээ нь баг бөх болон хэт олон бодис дууртэл хадгальсан эсэх, тавилур дээрх химийн бодисыг хана болон шаланд сайтар бэхжэгдсэн эсэхийг шалгаж аюулгүй байдлыг хангах	Тогтмол	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналатик/, Техникийн менежер, Шинженер /Элжийн/

6	Химийн хорт болон аюултай бодисын агуулахыг MNS 6458:2014 стандарт шаардлагад заасаны дагуу засварлаж, тохижуулах	2024 он	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/ Техникийн менежер, ХААХ, ҮТГазар
7	Химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажилладаг ажилтан наарт болзошгүй осол, эрсдлээс сэргийлэх, анхны тусламж үзүүлэх сургалтыг зохион байгуулах	Жилд 2 удаа	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/ Техникийн менежер
8	Химийн хорт болон аюултай бодисын зарцуулалтын бүртгэл хөтөлж, тайлан, мэдээг Сайхан сумын Засаг дэргэд жил бурийн 12-р сарын 15-ны дотор, Сэлэнгэ аймгийн БОДЖГ, БОАДЖАМ руу тус тус дараа оны 1-р сард хургуулэх	Тухай бурт	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/ Техникийн менежер
9	Химийн хорт болон аюултай бодисын агуулах болон химийн бодис ашиглах лабораторийн өрөөнүүдэд тус бүр дуу, дурс бичдэг камер сууринуулах	2-р улиралд	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/ Техникийн менежер, Мэдээлэл технологийн хэлтэс
10	Нэр төрөл, шинж чанар, хэрэллэх заавар тодорхой бус химийн хорт болон аюултай бодисыг эрх бүхий мэргэжлийн байгууллагын дүгнэлтийгээр ашиглахгүй байх	Тогтолц	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналитик/ Техникийн менежер
11	Химийн хортой бодисын хуванцар сав, аюултай хог хаягдлыг тухай бурт гэрэээт байгууллагад хургуулж, устуулах	Жилд 1 удаа	Мэргэжлийн байгууллага, ХААХ, СШЛаборатори, БОХэлтэс

12	Ашиглажгүй болсон химийн хорт болон аюултай бодисын хаягдлыг зөвшөөрөлтэй газраар, эрүүл мэнд, байгаль орчинд аюулгүй аргаар холбогдох комиссыг байцуулан устгаж, акт үйлдэх	2024 онд	СШЛабораторийн эрхлэгч, Инженер /Аналатик/ Техникийн менежер, БОМэрэжилтэн, мэргэжлийн байгууллага
----	--	----------	---

10.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Цемент Шохой ТӨХК-ийн нөөцийн үр ашигтай, хэмнэлттэй хэрэглээ, технологийг дэмжин хаягдлыг бууруулж, байгаль орчинд сөрөг нөлөө баатайгаар зайнуулах, хунд амд амьрах орчны эрүүл ахийн мэдлэг, зөв дадлыг олгох замаар хог хаягдлын зохицтой менежментийг төлөвшүүлж, цэвэр эрүүл орчин бурдудлах эндэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжи х нэгж	Нэлжийн зардал, төг	Тоо хэмжээ 3	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Хог хаягдлын баримт бичиг
1	Сургалт, суртчилгээ	Үйлдвэрийн нийт ажилчдад 2017 оны 5 дугаар сарын 12-нд батлагдсан хуулийн талаар танилцуулан, хог хаягдал ангиалан ялгах, аюултай хог хаягдлыг хадгалах,	Үйлдвэрийн нийт ажилтнууд	-	200,000	-	100,000	1,2 дугаар саруудад	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.6

	Антилах, серег нэлөөллийг бууруулах талаар сургалт, гарын тарааж сурчиллах	Үйлдвэрлэлийн цех, хэсгүүд, офис зэргээс гараах хаягдалд ялгалт хийж, энгийн хог хаягдлыг антилан тур хадгалах цэгт байрлуулах	- - - -	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.6
2	Ахуйн	Хог хаягдлын цэгийг шинэчлэн ицуу аюулгүй, боловсронгуй болгож тохижуулах, хаягжуулах	- - -	2024 оны тувш
3	Үйлдвэрийн н	Үйлдвэрлэлийн технологиос гарсан хаягдлыг(Козель	ТН -	Хог хаягдлын тухай хууль

шланз)	Үйлдвэрлэлд нэмэлтээр ашиглагдах, хаягдлын мэдээллийг сар бур авч байх	Үйлдвэрлэлд ашиглагдах боломжгүй технологийн хаягдлыг (тоос, клиникер, шохойн чулгууны нунтаг, УНС) Үйлдвэрлэлийн хог хаягдлын отвалруу тээвэрлэх, Үйлдвэрийн орчныг цэвэр байлагах, технологийн сажилга батыг нэмэгдүүлэх	Үйлдвэрийн бус ТН	2480 318,8 790,700

	Аюултай хаягдлын тусгайлан байгуулж, хязгаарлалтын бүс тогтоох	Хог хаягдлын тусгайлан байгуулж, хязгаарлалтын бүс тогтоох	Цементийн үйлдвэр, Шохойн үйлдвэр	Ш 100,000	2	200,000	II, III-р улиралц	Хог хаягдлын тухай хууль
4	Аюултай хаягдлын тусгайлан байгуулж, хязгаарлалтын бүс тогтоох	Хог хаягдлын (редуктор, ашигласан тос, химийн бодисны сав, тосны шүүр, дүүгүй) хайрцааг, сав аюулаас сэргэмжлүүлсэн тусгай таних тэмдэг, нэр, хаягийг ил тод хадаж, тусгай газар хадгалаан бүртгэл хөтөн тайлан гаргаж байх	ЦШ лаборатори, Уйлдвэрүүд	-	-	-	БОАЖГ-аар өгөгдсөн зөвлөмжийн дагуу	Хог хаягдлын тухай хууль
5	Гэрээ болон бусад	Уйлдвэрээс гарах ахуйн хог хаягдлын гэрээг сумын тохиижилтийн	Байгаль орчны мэргэжилтэн хот	-	-	-	Улирал бүр	Хог хаягдлын тухай хууль

	газартай, Үйлдвэрлэлийн хог хаягдал хүримтлуулах отвалын Сайхан зДТГ-тай, аюултай хаягдлыг бухий байгууллагатай тус тус байгуулж ажиллах					
Дахин боловсруулах	хог хаягдлыг аж ахуй нэгж байгууллага болон хувь иргэнтэй гэрээ байгуулан борлуулах					
Хог хаягдлын бүртгэл, тайлан мэдээг Сэлэнгэ аймгийн БОАЖГ, Сайхан Орхон БОХУ-ЫН	Хог хаягдлын Үйлдвэрлийн бүх цех, нэгжүүд ш	I, II, III, IV-р улиралд	-	4*4	-	Хог хаягдлын тухай хууль

	байцаагч улирал хүргүүлэх	нарт бүр				
Нийт				1,090,70 0		

11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, аргачалат	
1	Орчны агаар дахь NO ₂ , SO ₂ , CO ₂	Шохой, Бутлуур, Чуулунцарын дамжлагууд, Тээрэм, Савлах	Улирал бүр	5	18,500	370,000		MNS4585:2007, MNS, ISO4227:2002, MNS0017-2-07:1979, MNS0017-2-1-01:1978, MNS4990:2000
2	Тоос PM10	Төмөр замын цех	Улирал бүр	1	20,000	80,000		
3	Цацрагийн үзүүлэлт	Бэлэн бутэгдэхүүнд /цемент, шохой/, Үйлдвэрлэлийн хог хаягдлын отвал орчмын хөрс	Улирал бүр 3 цэгээс радоны /Ra/	2	5,000	20,000		
4	Хөрсний үржил шимийн үзүүлэлтүүд /ялзмаг, РН, давсжилт, хөдөлгөөнд азот-NO ₃ -N, фосфор-P2O ₅ , кали-K ₂ O/, ширхэгийн бүрэлдэхүүн, нягт, эзлэхүүн, жин, ус нэвтрүүлэх чадвар, чийгшил	Дурын 3 байршилд	Улирал бүр 3 цэгээс	2	50,000	600,000		MNS 5916 : 2008

5	Хөрсний хүнд металлын бохирдол Хар тугагта /Pb/, Хром /Cr/, Цайр /Zn/, Никель /Ni/, Кадми /Cd/, ГЭХ, БОХЭТЛ/	Лабораторийн байр, засварын газар, хогийн отвал орчим	Улирал бур 3 цэгээс	2	36,000	432,000	MNS5850:2008 Хөрсний чанар. Хэрс бохирдуулагч бодис, элементүүдийн зэвшөөрөгдөх дээд хэмжээ
6	Нефтийн бүтээгдэхүүнээр бохирдох хөрсний бохирдол	Хөтөл-1, 2 орд	Улирал бур	2	50,000	200,000	
7	Үндны усны химийн бүрэн шинжилгээ /21 үзүүлэлт/	Усны эх Уусвэрийн худгуудаас дээж авах	Улирал бур	2*2	44,000	352,000	MNS0900:2005 Үндны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
8	Бактериологийн бүрэн шинжилгээ /6 үзүүлэлт/	Усны эх Уусвэрийн худгуудаас дээж авах	Улирал бур	2*2	10,000	80,000	
9	Бохир усны химийн бүрэн шинжилгээ /21 үзүүлэлт/	Ахуйн болон үйлдвэрээс гарсан бохир усыг цэвэрлэсний дараа	Улирал бур	2	22,000	88,000	MNS4943:2011 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус, ерөнхий шаардлага

	Ургамлын доройтол, талхагдал, зүйлийн хомсдол ургамлын терөл зүйлийн бүрдэл, - туслагийн бүрхэц – булгэмдлийн өөрчлөлт	Төслийн ойр орчмын нутаг дэвсгэрт	Жилд 1 удаа, ургамлы н бүрэн ургалты н хугацаа нд, 6-9 сарын хороонд 1 удаа	2 100,000 200,000
10	Зэрлэг амьтдыг тоолох, бүртгэх, популяци, нүүдэл, зүйлийн бурдлийг судлах	Үйлдвэрийн эзэмшил орчмын нутгийг хамарсан нутаг дэвсгэр	Нүүдлий н хугацаа нд /Х сард/ жилд 1 удаа	2 100,000 200,000
11	Нийт			2,622,000

**12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион
байгуулалтын төлөвлөгөө**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь		Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			Cap ...	Cap ...		

1	Байгаль хамгаалах сэргээх болон аюулгүй ажиллагааны сургалт байгуулах нөлөөллийг буурулах хэсэгт сэдвүүдийг дурдсан агуулгад багтаах/	Байгаль хамгаалах сэргээн болон аюулгүй ажиллагааны талаар зохион /сөрөг 400,000	1, 9-р сар	БОМЭРГЭЖИЛТЭН	Жилд 2 удаа байгаль орчны сургалт явуулах
2	Байгаль хамгаалах хийгдсэн тайлангаа хугацаанд аймгийн, Сайхан, БОХУ тайлагнах	орчныг асуудлаар ажлын тоогоосон Сэлэнгэ БОАЖГ, Орхон сумын байцаагчад	6, 9, 12-р саруудад -	БОМЭРГЭЖИЛТЭН	Улирлын тайлан хүргүүлэх
3	Үс ашиглах гаргуулж, зөвшөөрөл авч, гэрээ байгуулах	Сөрөг нэлөө бууруулах хэсээт тусгав.	6-р сар	Усны мэргэжилтэн	Уулын ажлын болон БОМТ баталгаажсаны дараа
4	Орон нутгатай хамтран ажиллах байгуулах	-	1-р сар	Захиргаа удирдлагийн газар	Орон нутгийн санал авч гэрээ байгуулах

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө- 2024 он

	Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмал хайгуул, ашиглалт явуулах аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны баримт бичгүүдийн хянан бүртгэх хуудсанд гарын үсэг зуруулж, баталгаажуулах	БОМТөлөвлөгөөний биелептийн тайлан баталгаажсаны дараа	3-р сар	БОМэргэжилтэн
5	Гал урьдчилан арга хэрэглээр хангах	Түймрээс сэргийлэх хэмжээ авах, багаж гапын	1,100,000	3-р сар
6	Ажлын анхан тусламжийн сэлбэх	байран дахь шатны хэрэгслийг	1,100,000	Хангамжийн дарга
7	Ашиглаж тоног бүрэн	буй техник техеөрөмжийн байдал	100,000	Жилийн турш Бодлогын хэлтсүүд
8				

	аюулгүй хангаж ажиллах			
9	Газар, ус ашигласны болон бусад төлбөрийг холбогдох эрхийн актанд заасны дагуу тухай бур төсвийн дансанд төвлөрүүлэх	-	Улирал бур	СБТХ-ийн газар Хуваарийн дагуу төлөлтийг хугацаанд Нь хийх
10	Байгаль орчныг хамгаалах, хаягдаа цэгт хөдөлмөрийн байдлын сургалчилгааны самбар байршуулах	хог тоогосон хаях, аюулгүй талаар хийж	4, 5-р сар 100,000	ХАБЭА, БОХЭЛТЭС Хог хаягдал ил задгай хаях асуудал багасна

11	Байгаль орчныг нэхэн сэргээх баталгаа болгож, 2024 онд байгаль орчныг хамгаалахад төлөвлөсөн зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгийг БОДЖЯМНЫ дансанд төвлөрүүлэх	3,175,000	1-р сар СБТХ-ийн газар
12	Ерөнхийлөгчийн санаачилсан “Нэг тэрбум мод” Үндэсний хөтөлбөрт зориулан төгөл байгуулах	-	2024 оны турш Захиргаа, БОХЭЛТЭС -
	Нийт	5,575,000	

13. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нэлүүслийн бусийн оршин суугчдад тайлгнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлгахад оролцогч талууд	Тайлгнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны төв	Тайлгнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилт ан	Зохион байгуулах газар
1	Сайхан сум	Илтгэл	2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөни й тайлан	2024 оны 9-р сард	300,000	БОХэлтэс	Сайхан сумын ЗДТГ
2	Номгон 3-р баатар	Илтгэл	2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөни й тайлан	2024 оны 9-р сард	300,000	БОХэлтэс	Номгон 3-р баатарын ЗДТГ
3	Орхон сум	Илтгэл		2024 оны 9-р сард	300,000	БОХэлтэс	Орхон сумын ЗДТГ
	Нийт				900,000		

Зардал нэгтгэл

№	Төлөвлөгөө, бүрэлдэхүүн хэсгүүд	Зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3,381,400
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	6,350,000
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	25,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,090,700
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2,622,000
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	5,575,000
10	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	900,000
НИЙТ		44,919,100